

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2025/029/НА-СТА-ТХН

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас:261663Цахим хаяг: naranchimegts@audit.mn

Аудитын менежер: А.Цогбаяр
Утас: 261885 Цахим хаяг: tsogbayar.a@audit.mn

Ахлах аудитор: Ж.Бүжинханд
Утас:261740 Цахим хаяг: bujinkhand.j@audit.mn

Гэрээгээр гүйцэтгэсэн: "Конфиденсе Аудит" ХХК-ийн
Захирал П.Ариунаа
Утас: 99994990 Цахим хаяг: info@confidenceaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.13 № 07/968
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

- Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банк хооронд 2020 оны 7 дугаар сарын 2-ны өдөр байгуулсан зээлийн гэрээнд төслийн үйл ажиллагаа 2026 оны 6 дугаар сарын 30-ны өдөр бүрэн дуусахаар тусгасан байна. Зээлийн гэрээнд заасан хэрэгжих хугацааны 81.8 хувь нь өнгөрсөн хэдий ч зээлийн ашиглалт хангалтгүй, зарцуулалт 5.4 хувьтай байгаа нь төсөл батлагдсан хугацаандаа хэрэгжих боломжгүй болсон;
- Төслийн хэрэгжилт удаан, үр ашиггүй байгаагаас Сангийн сайд санхүүжилт хийх боломжгүй болсон төслийн жагсаалтад оруулж, 2025 оны төсөв батлаагүй, 2025 оны эхний 2 сарын цалин олгогдоогүй, түрээсийн төлбөр болон бусад төлбөрүүд төлөгдөөгүй, төслийг цаашид хэрэгжүүлэх эсэх нь тодорхойгүй зэрэг зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Z:\Yawsan_Bichig\2025\0313 SNAG-15.Docx

1525070781

Төсвийн тухай хууль 6 дугаар зүйлийн 6.4.1. "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалын хавсралтын гурав дугаар бүлгийн 7.3-д "Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлж, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд төсөл, арга хэмжээний үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллана" гэсэн заалтуудтай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сангийн сайдын ирүүлсэн чиглэл хүргүүлэх тухай 2024 оны 12 сарын 30-ны өдрийн албан бичигт зөвлөх үйлчилгээний гэрээний санхүүжилтийг зогсоох, хойшлуулах тухай арга хэмжээ авахаар заасны дагуу дотоодын 2 зөвлөхийн нийт 273,845.6 мянган төгрөгийн гэрээг зогсоох тухай сонсох ажиллагааг явуулсан ба чөлөөт бүсийн менежментийн зөвлөх консорциумын 4,788,247.4 мянган төгрөгийн гэрээг зогсоох тухай мэдэгдэл хүргүүлэхээр шийдвэрлэн ажиллаж байна.

Бусад асуудал

Азийн хөгжлийн банканд илгээдэг төслийн үйл ажиллагааны тайланд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар төслийн ерөнхий төлөвлөгөөний нийт хугацааны хорогдол 75 хувь (4,5 жил), ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт 11.2 хувьтай явагдаж байгаа ба 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийт 4 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 23 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэл 59.1 хувьтай байна гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ



2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.2 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	475,402,871.14	1,185,216,162.72
31	МӨНГӨН БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	472,432,871.14	1,097,412,931.75
3121	Банканд байгаа бэлэн мөнгө	8,608,738.25	11,907,428.34
31221	Төрийн сангийн харилцах	463,824,132.89	1,085,505,503.41
	Бусад авлага		84,833,230.97
34	Урьдчилгаа	2,970,000.00	2,970,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	2,970,000.00	2,970,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	243,079,294.66	229,489,220.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	243,079,294.66	229,489,220.64
392	Биет хөрөнгө	241,212,627.90	228,322,553.84
39203	Тээврийн хэрэгсэл	154,545,454.55	170,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл		(17,000,000.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	67,066,697.50	75,519,497.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,944,457.25)	(42,296,996.73)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,448,799.70	19,448,799.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,862,199.91)	(6,807,079.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	35,000,000.00	35,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,041,666.69)	(5,541,666.73)
393	Биет бус хөрөнгө	1,866,666.76	1,166,666.80
39301	Программ хангамж	3,500,000.00	3,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,633,333.24)	(2,333,333.20)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	718,482,165.80	1,414,705,383.36
4	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	189,658,311.03	1,352,292,550.66
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	189,658,311.03	1,352,292,550.66
413	Өглөг	189,658,311.03	1,352,292,550.66
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	8,639,668.80	
41361	Байгууллагад өгөх өглөг	163,455,454.55	1,352,168,550.66
41362	Хувь хүмүүст өгөх өглөг	17,563,187.68	124,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	528,823,854.77	62,412,832.70
51	Засгийн газрын хувь оролцоо	528,823,854.77	62,412,832.70
512	Хуримтлагдсан үр дүн	528,823,854.77	62,412,832.70
51210	Өмнөх үеийн үр дүн	528,823,854.77	528,823,854.77
51220	Тайлант үеийн үр дүн		(466,411,022.08)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ӨМЧИЙН ДҮН	718,482,165.80	1,414,705,383.36

Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.3 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,181,818.18	3,233,282,376.12
12	Татварын бус орлого	3,181,818.18	3,233,282,376.12
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,181,818.18	3,233,282,376.12
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,181,818.18	16,222,981.81
141001	Гадаадын санхүүгийн зээлийн эх үүсвэр		3,216,860,517.31
335113	Бусад орлого		198,877.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	490,444,818.72	3,708,724,523.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	490,444,818.72	3,708,724,523.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	490,444,818.72	3,708,724,523.07
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	187,228,476.19	309,235,695.94
210101	Үндсэн цалин	187,228,476.19	309,235,695.94
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,336,503.52	36,815,156.32
210201	Тэтгэврийн даатгал	15,914,420.47	26,244,330.67
210202	Тэтгэмжийн даатгал	1,872,284.76	3,261,530.91
210203	ҮОМШе-ний даатгал	1,497,827.81	2,087,284.73
210204	Ажилгүйдлийн даатгал	368,360.95	474,728.19
210205	Эрүүл мэндийн даатгал	3,683,609.53	4,747,281.82
2103	Байр ашиглалтын холбоотой тогтмол зардал	35,640,000.00	35,640,000.00
210304	Байрны түрээс	35,640,000.00	35,640,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,282,584.98	13,855,214.21
210401	Бичиг хэрэг	1,844,660.00	3,505,200.00
210402	Тээвэр, шатахуун	292,059.00	5,156,472.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,808,265.98	3,793,561.21
210404	Ном, хэвлэл	97,600.00	336,400.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	240,000.00	1,063,581.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	361,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		361,300.00
210604	Урсгал засвар	2,000,000.00	
2107	Томилолт, зочны зардал	7,337,572.00	14,216,989.00
210604	Дотоод албан томилолт	7,337,572.00	14,216,989.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	208,056,032.94	3,246,656,804.12
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	194,285,947.94	3,240,500,902.13
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,063,700.00	
210803	Даатгалын үйлчилгээ		2,888,740.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	22,585.00	158,010.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо		50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,563,800.00	2,462,814.00

Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	120,000.00	596,337.99
2109	Бараа ажил үйлчилгээний бусад зардал	21,563,649.09	51,943,363.48
210901	Бараа ажил үйлчилгээний бусад зардал	3,463,763.00	14,445,944.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	18,099,886.09	37,497,419.48
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(487,263,000.54)	(475,442,146.95)
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		9,031,124.88
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		9,031,124.88
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,772,411.90	
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	2,772,411.90	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(2,772,411.90)	9,031,124.88
5	НИЙТ ҮР ДҮН	(490,035,412.44)	(466,411,022.08)

Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	3,216,860,517.31
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	3,216,860,517.31
122	Тусламжийн орлого	-	3,216,860,517.31
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих /гадаад/	-	3,216,860,517.31
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	437,232,076.16	2,445,860,433.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	437,232,076.16	2,445,860,433.72
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	437,232,076.16	2,445,860,433.72
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	180,469,639.40	315,994,532.74
210101	Үндсэн цалин	180,469,639.40	315,994,532.74
2102	Ажил олгогчоос нийтийн даатгалд төлөх шимтгэл	21,455,671.52	38,700,515.41
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	21,455,671.52	38,700,515.41
2103	Байр ашиглалтын холбоотой тогтмол зардал	26,730,000.00	44,550,000.00
210304	Байрны түрээс	26,730,000.00	44,550,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,282,584.98	12,690,342.21
210401	Бичиг хэрэг	1,844,660.00	3,505,200.00
210402	Тээвэр, шатахуун	292,059.00	3,991,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,808,265.98	3,793,561.21
210404	Ном, хэвлэл	97,600.00	336,400.00
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	240,000.00	1,063,581.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	8,045,663.64
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	8,045,663.64
210604	Урсгал засвар	2,000,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	7,337,572.00	15,381,861.00
210604	Дотоод албан томилолт	7,337,572.00	15,381,861.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	190,492,845.26	1,996,531,774.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	176,722,760.26	1,989,895,672.73
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,063,700.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	2,888,740.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	22,585.00	158,010.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	50,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,563,800.00	2,943,014.00
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	120,000.00	596,337.99
2109	Бараа ажил үйлчилгээний бусад зардал	3,463,763.00	13,965,744.00
210901	Бараа ажил үйлчилгээний бусад зардал	3,463,763.00	13,965,744.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(437,232,076.16)	771,000,083.59
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	31,818,181.82	154,545,454.55
223001	Бусад хөрөнгө	31,818,181.82	154,545,454.55
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(31,818,181.82)	(154,545,454.55)

Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	8,525,431.58
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	2,772,411.90	-
9	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(471,822,669.88)	624,980,060.62
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	944,255,541.02	472,432,871.14
11	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	472,432,871.14	1,097,412,931.75

2.5 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	1,018,859,267.21	1,018,859,267.21
2	Тайлант үеийн үр дүн	-	(490,035,412.44)	(490,035,412.44)
3	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	528,823,854.77	528,823,854.77
4	Тайлант үеийн үр дүн	-	(466,411,022.08)	(466,411,022.08)
5	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	-	62,412,832.70	62,412,832.70

Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,626,000,000.00	2,600,405,888.27	1,025,594,111.73	71.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,460,000,000.00	2,445,860,433.72	1,014,139,566.28	70.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,460,000,000.00	2,445,860,433.72	1,014,139,566.28	70.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	325,000,000.00	315,994,532.74	9,005,467.26	97.2
210101	Үндсэн цалин	325,000,000.00	315,994,532.74	9,005,467.26	97.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,229,500.00	38,700,515.41	4,528,984.59	89.5
210201	Тэтгэврийн даатгал	29,950,600.00	27,967,897.76	1,982,702.24	93.4
210202	Тэтгэмжийн даатгал	3,722,500.00	3,261,530.91	460,969.09	87.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,250,000.00	2,250,000.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,861,300.00	861,581.65	999,718.35	46.3
210205	Эрүүл мэндийн даатгал	5,445,100.00	4,359,505.09	1,085,594.91	80.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	44,550,000.00	44,550,000.00	-	100.0
210304	Байрны түрээс	44,550,000.00	44,550,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	14,784,500.00	12,585,761.21	2,198,738.79	85.1
210401	Бичиг хэрэг	4,657,000.00	3,763,100.00	893,900.00	80.8
210402	Тээвэр, шатахуун	4,500,000.00	3,991,600.00	508,400.00	88.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,590,000.00	3,793,561.21	796,438.79	82.6
210404	Ном, хэвлэл	37,500.00	37,500.00	-	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,685,000.00	7,684,363.64	636.36	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,685,000.00	7,684,363.64	636.36	100.0
2107	Томилолт, зочны зардал	16,000,000.00	15,381,861.00	618,139.00	96.1
210702	Дотоод албан томилолт	16,000,000.00	15,381,861.00	618,139.00	96.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,993,750,000.00	1,996,531,774.72	997,218,225.28	66.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,975,000,000.00	1,989,895,672.73	985,104,327.27	66.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	11,440,000.00	-	11,440,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	3,000,000.00	2,888,740.00	111,260.00	96.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	320,000.00	158,010.00	161,990.00	49.4
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	50,000.00	50,000.00	50.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,890,000.00	2,943,014.00	946,986.00	75.7
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	596,337.99	(596,337.99)	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,001,000.00	14,431,625.00	569,375.00	96.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,001,000.00	14,431,625.00	569,375.00	96.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	166,000,000.00	154,545,454.55	11,454,545.45	93.1
22000	Барилга байгууламж	1,000,000.00	-	1,000,000.00	-

**Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төслийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан**

22200	Тоног төхөөрөмж	165,000,000.00	154,545,454.55	10,454,545.45	93.7
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,626,000,000.00	3,216,860,517.31	409,139,482.69	88.7
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,626,000,000.00	3,216,860,517.31	409,139,482.69	88.7
350004	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	3,626,000,000.00	3,216,860,517.31	409,139,482.69	88.7
154001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		8,525,431.58		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		472,432,871.14		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		1,097,412,931.75		
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	6	6	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	1	1	-	100.0

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1. Аудитаар нийт 84.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 84.8 сая төгрөгийн зөрчлийг залруулж, 1 зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлсэн.

Аудитаар нийт 84.8 сая төгрөгийн алдаа илрүүлснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нийгмийн даатгалын байгууллагатай тооцоо нийлсэн акт болон бүртгэл дэх тооцооны үлдэгдэл 4.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	1	-	1	-	-	-	1	-	-	-	-	-
Ажилтны цалингаас ХХОАТ-ын 124.0 мянган төгрөг илүү суутгаж, татварын тайланд тусгасан.	1	0.1	-	-	1	0.1	1	0.1	-	-	-	-
Шатахууны картын хөнгөлөлтийн орлогыг бүртгээгүйгээс картын үлдэгдэл болон бүртгэл дэх үлдэгдэл 198.9 мянган төгрөгөөр зөрүүтэй.	1	0.2	1	0.2	-	-	1	0.2	-	-	-	-
Тайлант онд гэрээ байгуулсан оршин суугч бус этгээдээс 84,505.8 мянган төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвар суутган аваагүй, татварт өглөг үүсгээгүй.	1	84.5	1	84.5	-	-	1	84.5	-	-	-	-
Дүн	4	84.8	3	84.7	1	0.1	4	84.8	-	-	-	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

3.2. Нийцлийн аудиттай холбоотой 1 зөрчил илэрсэнд зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлээ.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомж						
Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаа эхлээд төлөвлөгдсөн хугацааныхаа 81.8 хувьд хүрээд байгаа боловч ч зээлийн зарцуулалт нь нийт зээлийн 5.4 хувь болж төлөвлөсөн хугацаанаасаа хоцорч байна.	1	-	1	-	-	-
Дүн	1	-	1	-	-	-